



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestl.mn, Вэбсайт: www.ett.mn

2024.06.26 № 01/1165

танай _____-ны № _____-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240102487 дугаартай “Ухаалаг пүүний тоног төхөөрөмж, нэвтрэх систем” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 11.1-т заасны дагуу дээрх тодруулга нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

Хавсралт: *2* хуудас.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ

1124050747



Тодруулгын хариу

Тендерийн нэр	Ухаалаг пүүний тоног төхөөрөмж, нэвтрэх систем
Тендерийн дугаар	ЭТТХК/20240102487
Тендер зарласан огноо	2024 оны 06 дугаар сарын 06
Тендер нээх огноо	2024 оны 07 дугаар сарын 04
Тодруулга №1	
Тодруулга	Хариу
Бүх пүүг нэгдсэн холбох сүлжээ, дэд бүтэц дээр дотоод сүлжээ гэж дурдсан байгааг пүү бүр дээр ЭТТ-ийн дотоод сүлжээтэй холбогдсон уу?	Бүх автожин дотоод сүлжээнд холбогдсон.
Тодруулга №2	
Тодруулга	Хариу
Техникийн тодорхойлолтын 2.1.4-т тусгайлан дугаар таних камер шаардлагагүй гэж орсон байна. Гэвч материалын түүвэр дээр дугаар таних камер орсон байна. Техникийн тодорхойлолтыг дагах уу, материалын түүврийг дагах уу?	Автожин нь оролт, гаралт, хяналтын гэсэн 3 төрөл байх ба “чингэлгийн дугаар таних камер”-ийг зөвхөн оролтын пүүнд байршуулах бөгөөд Зураг 4-т тодорхой харуулсан байгаа. Хяналтын болон гаралтын автожинд чингэлгийн дугаар таних камер шаардлагагүй. Материалын түүврийн хамгийн арын баганад “чингэлгийн дугаар таних камер”-ийг ямар пүүнд зориулж авахыг тодорхой заасан.
Тодруулга №3	
Тодруулга	Хариу
Камерын шаардлагад Genetec system-д холбогддог байх гэсэн үзүүлэлтийг энгийн камерт тавьж өгөөд дугаар таних камерт тавьж өгөөгүй байгаа нь дугаар таних камер Genetec system-д холбогдох шаардлагагүй гэж ойлгох уу?	Ухаалаг автожингийн тоног төхөөрөмж худалдан авч буй энэхүү тендерт “ерөнхий хяналтын камер”, “чингэлгийн дугаар таних камер” гэсэн 2 төрлийн камер худалдан авна. Genetic system-д холбогддог байх камер нь “ерөнхий хяналтын камер”-т хамааралтай, “чингэлгийн дугаар таних камер” нь Genetic system-д холбогдох шаардлагагүй.
Тодруулга №4	
Тодруулга	Хариу
Нэгдсэн хяналтын программын хувьд Ажилчдын бүртгэл нэвтрэх системийн программ дурдагдсан хэр нь Пүүний нэгдсэн хяналтын систем дурдаагүй байгааг ЭТТ ХК нэгдсэн хяналтын систем дээрээ пүүний хяналт хийх гэж байгаа гэж ойлгох уу? Уг пүүний нэгдсэн хянах модуль хөгжүүлэлт хийгдсэн байгаа юу? Аль шатандаа явж байгаа вэ?	“Ухаалаг пүүний тоног, төхөөрөмж болон RFID” тендер нь тээврийн системийн hardware систем бөгөөд манай сервертэй холбогдож өгөгдөл солилцохоор программчлагдсан байх шаардлагатай.
Тодруулга №5	
Тодруулга	Хариу
Автожинг тоноглож буй төхөөрөмжүүд IP67 стандартыг хангасан байна гэсэн ерөнхий	Энэхүү тендерт худалдан авахаар төлөвлөсөн тоног төхөөрөмжүүд нь гадна

<p>шаардлагатай байна. Тоноглолуудын ерөнхий шаардлага салхи, шуурга зэрэг нь тоос шорооны хамгаалалт нь буюу IP67-ийн эхний оронгоор илэрхийлэгдэх юм. 2 дахь орон нь ус чийгийн хамгаалалт бөгөөд бороонд гадна ажиллахад 5,6,7 бүгд тохиромжтой байдаг. Учир нь борооны дусал 6мм-ээс дээш диаметртэй байдаг бөгөөд уг шаардлагыг 5,6,7 бүгд хангадаг. Тиймээс тоос шорооны хамгаалалт 6-аар, усны хамгаалалт, 5,6,7 байж болох уу? Жишээ нь IP65, IP66, IP67</p>	<p>орчинд орчинд ажиллах бөгөөд тоос шорооноос бүрэн хамгаалагдсан байх, ус ихтэй аадар бороотой нөхцөлд ус чийгт тэсвэртэй байхыг шаардах буюу IP66 шалгуурыг хангасан байж болно.</p> <p>Тоног төхөөрөмжүүдийн цахилгааны монтаж, холболтууд нь газрын гадаргаас доош 30 см-ээс багагүй гүнд хийгдэх тул богино хугацааны усанд булагдах, байнгын чийгтэй байх нөхцөл үүсэж болзошгүй учир цахилгааны холболтыг IP67 шалгуурыг хангасан материалаар хийх шаардлага тавьж байгаа болно.</p>
--	--